



**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР, НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН
2023 ОНЫ ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТЭД
ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН ТАЙЛАН-ЗӨВЛӨМЖ**

Хаяг:

***Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын
Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс
Нутгийн удирдлагын ордон 412 тоот***

Нээлттэй байдал :

***zavkhan.gov.mn сайтын аймгийн ЗДТГазрын
ХШҮХэлтсийн цэснээс тайланг үзнэ үү.***

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.МЯГМАРСҮРЭН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА
Н.БЯМБАДОРЖ

ХЯНАЛТ-ҮНЭЛГЭЭ ХИЙЖ
ЗӨВЛӨМЖИЙГ НЭГТГЭН
БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН
Б.ХУЛАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Иргэдээс төрийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдол холбогдох хууль тогтоомжийн дагуу цаг хугацаандаа шийдвэрлэсэн байдалд явцын хяналт-үнэлгээг хийж холбогдох заавар зөвлөмжийг өгч, төрийн байгууллагуудаас иргэдийн санал, өргөдөл гомдлыг Иргэн төвтэй-төрийн үйлчилгээний жилийн хүрээнд шуурхай шийдвэрлэн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд оршино.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ:

Монгол Улсын “Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2018 оны А/520 дугаар захирамжаар батлагдсан “Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг үндэслэн аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт болон нутгийн захиргааны байгууллагуудад иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГА

Аймаг, сумдын Засаг даргын тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний хэлтэс, агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн газар зэрэг нийт 60 гаруй байгууллага хамрагдлаа.

НЭГ. МЭДЭЭ ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт болон сум байгууллагуудад ирсэн өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар болон амаар, бичгээр хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажилласан байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

(Хүснэгт 1)

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт хувь
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	174	170	-	-	4	97.7
2	Нутгийн захиргааны байгууллага	1123	1098	10	5	10	97.06
IV улирлын дүн		1297	1258	10	5	14	96.9

Аймаг, сумын Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын дарга, эрхлэгч нарт хандаж ирүүлсэн 365 өргөдөл, 56 гомдол, 6 саналыг холбогдох хууль тогтоомж, эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэн, хариуг хүргүүлэн ажилласан байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт /хэлбэрээр/

(Хүснэгт 2)

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:					Бусад
			Бичгээр	ЗГИОНХ төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзуулсан	
1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	174	154	-	2	18	-	-
2	Нутгийн захиргааны байгууллага	1123	1088	-	-	25	10	-
IV улирлын дүн		1297	1242	-	2	38	10	-

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн агуулга

(Хүснэгт 3)

№	Аймгийн нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/			
1	Завхан аймаг	Нийт 4408 өргөдлөөс	1.Хүсэлт	1194 (96.05%)	
			2.Гомдол	90 (3.62%)	
			3.Санал	6 (0.32%)	
		Асуудлын нэр		Нийт тоо	Нийт хувь
		Газрын харилцаатай холбоотой		390	30.65%
		Төрийн байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой		284	22.84%
		Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой		156	12.5%
		Ажил, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой		154	12.3%
		Дэмжлэг, тусламж хүссэн		109	8.76%
		Цалин тэтгэмжтэй холбоотой		43	3.45%
		Төсөл хөтөлбөртэй холбоотой		11	0.88%
		Тусгай зөвшөөрөл хүссэн		12	0.96%
Байгаль орчинтой холбоотой		6	0.48%		
Хөдөө аж ахуйтай холбоотой		6	0.48%		
Бусад		81	6.5%		

1.Иргэдээс тусламж хүссэн өргөдөл ирүүлснийг аймаг, сумын Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс шийдвэрлэж, тусламж дэмжлэгийг үзүүлсэн. Аймгийн Засаг даргын нөөц сангаас 50.7 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан байна.

2.Байгууллагад шинээр ажилд орох, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой өргөдлийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд шийдвэрлэн ажилласан.

3.Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газар өмчлөх, эзэмших, газрын гэрчилгээ гаргуулах, эрхээ шилжүүлэх зэрэг газрын холбогдолтой хүсэлтүүдийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, саналаас шууд шийдвэрлэх, хүсэлтийг бүрэн барагдуулах боломжгүй өргөдлийг агуулгаар нь ангилж, дараах байдлаар гаргалаа.

(Хүснэгт 4)

№	Байгууллагын нэр	Шийдвэрлэхэд хүндрэлтэй өргөдлийн агуулга						
		Шүүхийн асуудал	Өндөр дүнтэй санхүүгийн тусламж	Орон сууцанд хамруулах	Гэр олгох	Зээлээс чөлөөлөх	Ажлын байраар хангах	Өндөр өртөгтэй эмчилгээний зардал

1	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар	-	-	5	29	1	11	2	-
2	Нутгийн захиргааны байгууллага	-	4	2	-	-	25	-	-
IV улирлын дүн		-	4	7	29	1	36	-	-

Өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэхдээ тухай бүр асуудлыг судалж, шаардлагатай үед ажлын хэсгийг томилон дүгнэлт гаргасан. Мөн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангасан.

Ололттой талууд

- Аймгийн Засаг даргын тамгын газар нь нийт өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд хугацаа хоцроосон өргөдөл, гомдол байхгүй байна.
- Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар хуваарийн дагуу иргэдтэй биечлэн уулзаж санал хүсэлтийг шийдвэрлэж ажилласан байна.
- Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах 7046-1212 утсыг 24 цагаар ажиллуулж, ирүүлсэн санал, гомдлыг 7 хоногийн дотор шийдвэрлэн хариуг хүргүүлж үр дүнтэй ажилласан байна.

Зөрчил, дутагдал

- Нутгийн захиргааны байгууллагад ирсэн 5 өргөдлийг хугацаа хоцроож шийдвэрлэсэн байна.



ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1. Аймгийн ЗДТГ-ын болон холбогдох төрийн албан хаагч бүртгэлийг нарийвчлан хөтөлж, мэдээний хамралтыг сайжруулан, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, үр дүнг удирдлагуудад танилцуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2. Өргөдөл, гомдлын мэдээ тайланг хугацаа хожимдуулсан, хариуг хугацаанд нь барагдуулаагүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон, тавих хяналтыг сайжруулах.

3.Иргэдийн өргөдөл, гомдолд тусгагдсан асуудлуудыг өөрийн байгууллагын хэрэгжүүлэх бодлого, авах арга хэмжээнд тусган хэрэгжүүлэх.

4.Хууль тогтоомж, журамд заасны дагуу иргэдийн өргөдөл гомдол, санал хүлээн авах хуваарь, журам, мэдээ тайланг байгууллагын вэб сайтад ил тод нээлттэй мэдээлэх.

5.Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг нотлох баримтаар баталгаажуулан, ойлгомжтой, тодорхой байдлаар өгөх.

6. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхдээ мэдээллийн аюулгүй байдал нууцлалтыг чанд ханган ажиллах шаардлагатай.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**